



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/80

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг цахимаар нийтэд нээлттэй ил тод зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 900 000 төгрөг (Хоёр сая есөн зуун мянган)-ийг Захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 15-ны өдрийн
А/ 80 дугаар захирамжийн хавсралт

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| Д/д | Тоног төхөөрөмжийн нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Дүн /мян.төг/ |
|-----|---|-------------|------------|-------------------------|---------------|
| 1. | Камер Үзүүлэлт: Камер-PTZ 20х, Full HD video, 1920*1080 нягтрал, удирдлага PTZ, холболт USB. | ш | 1 | 2 900 000 | 2 900.0 |
| 2. | Дууны хэрэгсэл. Үзүүлэлт: 360 6mics, 3W Dynamic, automat, холболт USB, battery 4000mah, 18650. | ш | 1 | | |
| 3. | Камерийн хөл /багцын худалдан авалтанд камерын хөл бэлгэнд дагалдуулна/ | ш | 1 | | |
| ДҮН | | | | | 2 900.0 |

-oOo-